



Хөндлөнгийн Боловсролын Үнэлгээний Удирдамж

Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Боловсролын тухай Хууль (*Цаашид “IDEA” гэх*)-ийн дагуу аливаа эцэг/эх нь сурагчийн орон нутгийн боловсролын байгууллага (*Цаашид “LEA” гэх*)-с гаргасан үнэлгээтэй санал нийлэхгүй бол сурагчид хөндлөнгийн боловсролын үнэлгээ (*Цаашид “IEE” гэх*)-г төсвийн зардлаар гаргуулан авах эрхтэй. IEE гэдэг нь тухайн хүүхдийн боловсрол хариуцсан LEA-д ажилладаггүй, мэргэшсэн үнэлгээчин эсвэл үнэлгээчид гүйцэтгэсэн үнэлгээ юм. Эцэг/эх нь LEA-с санал нийлээгүй үнэлгээ гаргасан тохиолдол бүрд IEE-г зөвхөн нэг удаа төсвийн зардлаар гүйцэтгүүлэх эрхтэй байна.

IEE гүйцэтгүүлэх хүсэлтийг Арлингтоны Улсын Сургууль (AUC)-н Тусгай Хэрэгцээт Боловсролын Газарт iee@apsva.us имэйлээр эсвэл шуудангаар дараах хаягт илгээнэ: Arlington Public Schools, Office of Special Education, Director of Elementary Special Education, 2110 Washington Blvd., 2nd Floor, Arlington, Virginia 22204.

IEE хүсэлт хүлээн авсан даруйд AUC-с тухайн эцэг/эхэд IEE-г хаана гүйцэтгүүлж болох, мөн IEE-д тавигдах нөхцөл шаардлага зэрэг мэдээллийг хүргүүлнэ. AUC нь IEE гүйцэтгүүлэх хүсэлтийн мөрөөр шаардлагатай гэж үзвэл эрх зүйн зохих процессын хүрээнд сонгол явуулах хүсэлт гаргах эрхтэй.

Виржиниа мужийн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Тусгай Хэрэгцээт Боловсролын Хөтөлбөрүүдийг Зохицуулах хууль журмуудад: “... үнэлгээг явуулах байршил болон үнэлгээчний мэргэжлийн чадавхад тавигдах шаардлагууд зэргийг тусгасан үнэлгээнд тавих нөхцөл шалгуур нь тухайн боловсролын байгууллагаас үнэлгээ эхлүүлэхэд тавигддаг нөхцөл шаардлагуудтай адил байна.” гэж заажээ.

Эдгээр дүрэм журамд нийцүүлэн AUC дараах шалгууруудыг тогтоосон байна. Үүнд:

I. Үнэлгээчин нь:

- A. Виржиниа мужийн Боловсролын Зөвлөлийн хүчин төгөлдөр лицензтэй байх, хэрэв Мэрилэнд эсвэл Вашингтон ДС хотод үйл ажиллагаа явуулдаг бол үүнтэй дүйх мэргэжлийн лицензтэй байх ; эсвэл
- B. Виржиниа мужийн Эрүүл Мэндийн Мэргэжилтнүүд Хариуцсан Газраас олгосон тухайн шинжээч нь Виржиниа мужид мэргэжлээрээ үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хүчин төгөлдөр лицензтэй байх, хэрэв Мэрилэнд эсвэл Вашингтон ДС хотод үйл ажиллагаа явуулдаг бол үүнтэй дүйх мэргэжлийн лицензтэй байх.
- C. Харьяалагдах мэргэжлийн хяналтын байгууллагуудаас ямар нэгэн шийтгэл эдлээгүй байх, үүнд лиценз эзэмшдэг аливаа мужид лиценз цуцлагдах, түдгэлзүүлэх, юм уу сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.
- D. Виржина мужийн Арлингтон хотод тавин бээр (mile)-н хүрээнд (радиус)

үйл ажиллагаа явуулдаг байх.

- Е. Гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх тухай гэрээлэн гүйцэтгэгчийн гэрчилгээний өргөдлийг бөглөсөн байх.

II. Үнэлгээг явуулахдаа дараах стандарт, удирдамжийг баримтална. Үүнд:

- А. Аливаа сурагчид үнэлгээ явуулахаас өмнө үнэлгээчин нь энэ удирдамжийн 1-р хэсэгт заасан шаардлагуудыг хангах тухай АУС-с хангалттай гэж үзсэн бичиг баримтуудыг ирүүлэх бөгөөд улмаар АУС-с эдгээрийг баталж, үнэлгээ явуулахыг зөвшөөрсөн зөвшөөрөл авсан байх.
- В. Үнэлгээг ажлын байр, сургуулийн байр юм уу бусад зохих ёсны албан орчинд явуулна. Үнэлгээг бүхэлд нь АУС-с тухайн үнэлгээнд зөвшөөрөл олгосон үнэлгээчин хариуцаж гүйцэтгэнэ.
- С. Бүх шалгалтыг нэг бүрчлэн тусад нь явуулах ёстой.
- Д. АУС-д урьдчилан баталж, зохицуулснаас бусад тохиолдолд шалгалтын хувилбар, дүнгийн аргачлал юм уу эсвэл бусад үнэлгээний хэрэгслийн зөвхөн хамгийн сүүлийн шинэчлэгдсэн хувилбарыг ашиглах ёстой.
- Е. Бүх шалгалтыг тухайн шалгалтуудын гарын авлагад заасны дагуу гүйцэтгэж, дүгнэнэ.
- Ғ. Шаталсан буюу кластераас бүрдсэн бүх шалгалт эсвэл дэд хэсгүүдийг бүрэн гүйцэтгэх ёстой бөгөөд шаталсан буюу кластерт дүйх стандарт оноог хавсаргавал зохино.
- Г. Шалгалтуудыг сонгохдоо боловсролын талаар олж илрүүлсэн асуудал тус бүрийг хамаарахуйц байхаар сонгоно.
- Н. Бүх шалгалт нь арьс өнгө, соёлын хувьд тэнцвэртэй байх зарчимд нийцэх ёстой бөгөөд тэдгээрийг ашиглах тодорхой зорилгод нь нийцүүлэн хянаж баталгаажуулсан байх.
- И. Англи хэлний мэдлэг хязгаарлагдмал хүүхдийг үнэлэхэд ашиглагдах үнэлгээний материал, журмыг сонгохдоо хүүхдийн Англи хэлний чадварыг хэмжихэд чиглэх бус харин тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн цар хүрээ, тусгай хэрэгцээт боловсролын хэрэгцээг тодорхойлох шалгуураар сонгож, ашиглавал зохино.
- Ј. Зайлшгүй шалтгаанаар боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд бүх шалгалтыг хүүхдийн төрөлх хэлээр болон бусад харилцааны хэлбэрээр явуулах ёстой.
- К. Шалгалтыг хүүхдийн сул хөгжсөн мэдрэхүй, хөдөлгөөний юм уу харилцааны бэрхшээлийг үнэлэхэд чиглэх бус харин хүүхдийн бодит чадвар, сурлагын амжилт юм уу эсвэл тухайн шалгалтын анхны үүрэг зорилгыг үнэн бодитоор тусган харуулах зорилгоор сонгож, ашиглах ёстой. Зөвхөн тухайн шалгалтын үндсэн үүрэг зорилгод тухайлан тусгасан ур чадваруудыг үнэлэх шаардлагатай үед энэ шаардлага хамаарахгүй байж болно.
- Л. Албан бус/эсвэл стандарт бус үнэлгээний арга хэрэгслийг албан ёсны үнэлгээнд нэмэлтээр ашиглаж болно.

III. Үнэлгээний тайланд дараах стандарт, удирдамжийг баримтална. Үүнд:

- A. Холбогдох зан төлөвийн ажиглалтыг тайланд тусгасан байх.
- B. Хэрэв үнэлгээг стандарт нөхцөлд явуулаагүй бол стандарт нөхцөлөөс ялгагдах тодорхойлолтуудыг үнэлгээний тайланд оруулсан байх ёстой.
- C. Авсан шалгалтуудтай хамаарах бүх онооны хавсралтыг тайлантай хамт ирүүлэх ёстой. Шалгалтыг соёл, хэл зүйн хүчин зүйлс дээр үндэслэн сонгосон бөгөөд үр дүн нь хүчинтэйг гэрчилсэн мэдэгдлийг тайланд оруулах ёстой.
- D. Шинжээч нь шалгалтын үр дүнг тайлагнахдаа объектив байх ёстой. Шинжээч нь тодорхой хөтөлбөр, анги хуваарилалт, тухайн хөтөлбөрт тэнцэх эсэх талаар тодорхой санал гаргахгүй байх, учир нь мужийн хуулиар эдгээр шийдвэрийг өөр өөр мэргэжлийн төлөөлөл багтсан өргөтгөсөн хороо гаргах ёстой гэж заасан байдаг.
- E. Нэмэлт үнэлгээ хийх аливаа саналыг тухайн сургуулийн ажлын хэсэгт хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.
- IV. Дараах хураамж, зардал, шимтгэлийг АУС-аас тогтоосон байна. Үүнд:

Үнэлгээний төрөл	Хураамж
Сэтгэл судлалын	\$2,500 хүртэл
Боловсролын	\$1,500 хүртэл
Мэдрэл, сэтгэлзүйн	\$4,000 хүртэл
Нийгэм-соёлын	\$600 хүртэл
Хэл/ Яриа	\$950 хүртэл
Хөдөлмөр Засал	\$850 хүртэл
Физик эмчилгээ	\$850 хүртэл
Мэргэжлийн Зан Төлөвийн Үнэлгээ	\$2,000 хүртэл
Хөнгөвчлөх Технологи	\$1,200 хүртэл
Сонсгол судлал	\$400 хүртэл
Сонсголын Боловсруулалт	\$1,000 хүртэл
Харааны Үзлэг	\$400 хүртэл
Бусад Үнэлгээ	\$500 хүртэл

- V. Төлбөрийн нэхэмжлэл ирүүлэх журам:
- A. Үнэлгээчид гарын үсэг бүхий Үнэлгээний тайлангийн хуулбарыг АУС -н Тусгай Боловсролын Алба **болон** эцэг/эхэд **нэгэн зэрэг** хүргүүлнэ. АУС-ийн Тусгай Боловсролын Алба тухайн сурагчийн сургууль дээрх ажлын хэсэгт эх тайланг хүргүүлнэ.
- B. Үнэлгээний төлбөрийн нэхэмжлэл, W-9 маягт, [APS Stars Vendor Application](#)-ийг АУС-ийн Тусгай Боловсролын Газарт iee@apsva.us имэйлээр эсвэл баталгаат шуудангаар дараах хаягт илгээнэ:

Arlington Public Schools
Office of Special Education
Director of Elementary Special Education
2110 Washington Blvd., 2nd Floor
Arlington, Virginia 22204

Энэхүү удирдамжтай холбоотой асуудлаар АУС-н Бага, Дунд сургуулиудын Тусгай Хэрэгцээт Боловсрол хариуцсан Захиралтай (703) 228-6040 тоот утсаар холбогдоно уу.